ӨМНӨХ ҮГ



Миний бие МУИС-ийг төгсч, эрдэм номын ариун дагшин, өгөөж буянт их өргөө-Монгол Улсын Их Сургуулийн багш хэмээх эрхин алдрыг зүүснээс хойш даруй 30 жил өнгөрчээ. Энэ хугацаанд монгол бичиг, монгол хэлний түүхэн хэлзүй, "Монголын Нууц Товчоон", монгол түүхэн сурвалжийн эхийн судалгаа, төвд хэл зэрэг хичээлийг оюутан, магистрант, докторант нарт заахын сацуу он цагийн уртад элж шарласан судар номын хуудас эргүүлж, тархиа гашилгаж суудаг нэгэн.

1990 онд МУИС-ийн Монгол Судлалын Хүрээлэнгийн бүрэлдэхүүнд Эх бичиг судлалын тэнхимийг шинээр байгуулж, монголчуудын хэрэглэж ирсэн хэдэн зүйлийн үсэг бичгээр уламжилсан судар шастир, төвд, манж хэлээрх эх сурвалжийг судлах мэргэжилтнийг бэлтгэж эхэлсэн билээ. Уг санаачлагыг миний бие гаргаж, тэр үеийн Монгол Судлалын Хүрээлэнгийн захирал асан, профессор Ц.Шагдарсүрэнгийн хамт зүтгэсээр хэрэгжүүлэн анхны элсэлтээ авч байсан юм. Тэр цагаас хойш 16 жил өнгөрч, эх бичиг судлалаар мэргэшин

төгсөгчдөөс маань хэлшинжлэл, түүх, уран зохиол, буддын гүн ухааны чиглэлээр хэд хэдэн хүн докторын зэрэг хамгаалж, олон төгсөгч МУИС, МУБИС зэрэг их дээд сургууль, ШУА-ийн Хэл Зохиолын Хүрээлэн, Түүхийн хүрээлэн, Археологийн хүрээлэн, Үндэсний Төв Архив, Улсын Үндэсний Номын сан зэрэг эрдэм шинжилгээний байгууллагад ажиллаж байна.

Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал 30 боть бүтээлийг гаргахаар шавь нартайгаа нойроо хугаслан суух үед тэднийхээ махран хичээж буйг хараад өөрийн эрхгүй баярлаж, биеийн ядралаа сэтгэлийн өөгөөр дарж, нэгэн цагт зөв юмны төлөө "улайран" зүтгэж байжээ гэж бодсон билээ.

Аливаа улс үндэстэн бүр өөр өөрийн түүхтэй. Тэр түүхээ зөвхөн баримтад л тулгуурлаж тодруулдаг. Баримт нь янз бүр байвч тэдгээрийн дотроос түүхэн цаг үед ойрхон зохиогдсон эх сурвалж хамгийн чухал хэрэглэгдэхүүн болдог билээ.

Бидний өвөг дээдэс агт сундалж, илд агссан дайчин баатраас илүүтээ бэх зуурч бийр янтай нийлүүлсэн бичгийн их соёлтон байсны үр буянаар эх түүхийн чамлахааргүй сурвалж хэрэглэгдэхүүн уламжлан иржээ. Харин бид тэдгээр эх сурвалжийг ямар хэмжээнд ашиглаж, улс үндэстнийхээ уг түүхийг туурвиж ирэв гэдэг нь эргэцүүлж бодууштай зүйлийн нэг яах аргагүй мөн. Энэ тухайд эерэг дүгнэлт хэлэх боломж тун ховор гэдгийг түүх судлаач, сонирхогч хэн боловч хүлээн зөвшөөрөх болов уу.

Ганц жишээ дурдахад, манай зарим судлаач монголын түүхийн тулгар сурвалж бичиг "Монголын Нууц Товчоон"-оос эш татахдаа академич Ц.Дамдинсүрэнгийн шинэ үсгийн хөрвүүлгийг гол хэрэглэгдэхүүн болгодог. Тус

хөрвүүлэг нь нийтэд ойлгомжтой болгох үүднээс эртний үг хэллэгийг эдүгээчлэн найруулах, хожуу үеийн түүхэн сурвалж дахь домгийг шигтгэн оруулах зэргээр үндсэн эхэд баригдалгүй чөлөөтэй найруулсан хөрвүүлэг билээ. Үүнээс үүдэж, *"Монголын Нууц Товчоон"*-ы уг эхэд ерөөс байхгүй мэдээ зангийг өгүүлсэн мэтээр эш татсан ташаарал судалгааны бүтээлүүдэд цөөнгүй таардаг юм. Харин академичийн "Монголын Нууц Товчоон"-ы хөрвүүлэг бол монгол хэл, түүх, уран зохиолын гайхамшигт дурсгалыг өргөн олон уншигчдад таниулахад үнэлж баршгүй гавъяатай, утга зохиолын хэлний яруу тансаг найруулгаар буулгасан бүтээл гэдгийг онцлон хэлмээр байна.

Ямар боловч, эртний сурвалжийн үндсэн эхийг эдүгээчлэн өөрчилж, олон нийтэд зориулсан хэвлэл, харь орны зарим түүхчийн зориуд мушгин гуйвуулж, монгол угсаатныг зэрлэг балмадын дүр, бүдүүлэг харанхуйн хүлээсэнд баглан бичсэн ном зохиолын зүйлээс дам эшлэн, "тухайн тухай"-гаар эш баримт хийж, үүх түүхээ туурвидаг явуургүй аргыг баримталж болохгүй гэдэгт эрхэм уншигч та санал нийлэх буй за. Өөрөөр хэлбэл, нөхцөл боломж нэгэнт бүрдсэн энэ цаг үед монголын түүх, хэл, уран зохиол судлалд эх сурвалжийг өргөн хүрээнд ашиглах шаардлагатай байна. Чухам ийм бодлын үзүүрт хөтлөгдөж, эх бичиг судлаач шавь нар, түүхч нөхдийнхөө хамт *"Монголын Нууц Товчоон"*-оос А.Амарын *"Монголын товч түүх"* хүртэл монгол түүхэн сурвалжийн цуврал 30 ботийн хөрвүүлэг, тайлбарыг нийтлүүлэхээр зориг шулуудсан билээ. Энэ санаачлагыг маань Улсын Их Хурлын гишүүн, доктор (Ph.D), профессор А.Цанжид чинхүү сэтгэлээр дэмжиж, нөхцөл боломжоор бүрэн хангахын сацуу ажлын явцтай байнга танилцаж, хэвлэн нийтлүүлэх

зэрэг ажлыг хөөцөлдөн, үндэснийхээ түүх, соёлыг дээдлэх нэгэн үзүүрт сэтгэлээр хандсаныг онцлон тэмдэглэе.

Аливаа ажил хэлэхэд амар, хийхэд хэцүү байдаг. Хөрвүүлэг бол нэг бичгээс нөгөөд буулгахын төдий зүйл биш гэдгийг эртний ном судрыг байцаан шүүж, уг хэллэгийн утга учир, үнэн мөнийг эргэцүүлэн бодох, эрэн олохын зовлон зүдүүрийг амссан хэн боловч гадарлах биз ээ.

Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал 30 боть бүтээлийн хөрвүүлэг, тайлбарыг МУИС-ийн Эх бичиг-Алтай судлалын тэнхимд төвлөрөн хийж, гүйцэтгэх багийн бүрэлдэхүүнд МУИС-ийн Монгол Судлалын Төвийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, Монгол улсын төрийн шагналт, шинжлэх ухааны доктор, профессор Ц.Шагдарсүрэн, Эх бичиг-Алтай судлалын тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор Д.Бүрнээ, ахлах багш, докторант М.Баярсайхан, доктор Д.Заяабаатар, докторант Т.Жамъянсүрэн, О.Дэмчигмаа, НШУС-ийн Түүхийн тэнхимийн багш доктор, дэд профессор З.Лонжид, доктор С.Чулуун, ХЗДС-ийн багш, доктор Б.Баярсайхан, ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан доктор, дэд профессор С.Цолмон, доктор А.Пунсаг, Үндэсний түүхийн музейн захирал, доктор, профессор А.Очир, МУБИС-ийн Түүхийн тэнхимийн багш, доктор Ж.Гэрэлбадрах, Ц.Төрбат, МУИС-ийн докторант С.Дашдэжид, Э.Мөнх-Учрал, Д.Нямаа, Р.Төрдалай, Ч.Нэргүй, магистр С.Амарбаяр, Д.Бүдсүрэн, магистрант Б.Баяртуяа, Л.Халиун, Ц.Батдорж, Б.Пүрэвдэлгэр, Эх бичиг судлалын 3-р ангийн оюутан П.Бямбахорол нар оролцсон болно..

Миний бие уг ажлыг гардан удирдаж, хувийн номын сангийнхаа ном судрыг тулгуур хэрэглэгдэхүүн болгон ашиглаж, бүх ботийг хянан нягтлахын сацуу ажлын явцад хүн бүрд байнга зөвлөж, өөрийн мэдэх чадахын чинээгээр хамтарсан билээ. Гэсэн хэдий ч уг нүсэр ажлын явцад анзааралгүй өнгөрсөн, алдаж эндсэн тохиолдол байхыг үгүйсгэхгүй бөгөөд тэр бүхнийг эрхэм уншигч та мэргэн оюундаа шүүн тунгааж, санал бодлоо хуваалцана буй за.

Уг цуврал бүтээлийг уншигчдын хүртээл болгоход хичээл гарган тусалсан шавь нартаа чин сэтгэлээсээ талархал илэрхийлье. Энэ цуврал номыг бүтээн туурвихад ивээн тэтгэлцсэн Зам тээвэр, Аялал жуулчлалын яам болон үзэмж чанартай хэвлэсэн Д.Лувсандорж захиралтай "Соёмбо принтинг" хэвлэлийн компанийн хамт олонд бас нэгэн адил талархлаа илэрхийлье.

Энэхүү цуврал бүтээл монголын судлалын дутуу дурганыг нөхөж, өргөн олон уншигчийн мэдлэгийн далайд дусал нэмэр болоосой хэмээсэн өмнөх үг үүнийг номын мөр хиргүй цагаан, хүмүүний сэтгэл буртаггүй ариун байхын бэлгэт ерөөлөөр өндөрлөсүгэй.

Хэлшинжлэлийн шинжлэх ухааны доктор,
профессор, гавъяат багш Шаравын ЧОЙМАА

Улаанбаатар хот
Монгол Улсын Их Сургууль
Эх бичиг-Алтай судлалын тэнхим
2006 оны 7 сарын 30



Монголын нууц товчоон

Нэгдүгээр бөлөг

1. Чингис хааны узуур.

Дээр тэнгэрээс заяат төрсөн Бөртэ чоно ажгуу. Гэргий инү Хоо марал ажээ. Тэнгис гэтэлж ирэв. Онон мөрний тэргүүнээ, Бурхан халдунаа нутаглаж төрсөн Батачихан ажгуу.

2. Батачиханы хөвүүн Тамача, Тамачийн хөвүүн Хоричар мэргэн, Хоричар мэргэний хөвүүн Уужим Борохул, Уужим Борохулын хөвүүн Сали Хачагу, Сали Хачагугийн хөвүүн Их Нүдэн, Их Нүдэний хөвүүн Сэм Сочи, Сэм Сочийн хөвүүн Харчу.

3. Харчугийн хөвүүн Боржигидай мэргэн, Монголжин гоо гэргийт ажгуу. Боржигидай мэргэний хөвүүн Торголжин баян, Борогчин гоо гэргийт, Боролдай Суялби залуут*, дайр, бор хоёр хүлэг агтаст* бүлгээ. Торголжины хөвүүн Дува сохор Добун мэргэн хоёр бүлгээ.

* ***залуут*** - *залуу зарцтай*

* ***Хоёр хүлэг агтаст*** - *хоёр хүлэг агттай*

4. Дува сохор магнай думд гагц нүдэт, гурван нүүрдийн газраа* харах бүлгээ.

* ***Гурван нүүрдийн газраа*** - *гурван нүүдлийн газарт*

5. Нэгэн өдөр Дува сохор, Добун мэргэн дүү лүгээ бээн* Бурхан халдун дээр гарав. Дува сохор Бурхан халдун дээрээс харж, Түнхэлиг горхи уруу нэгэн бөлөг иргэн* нүүж орж айсахыг харж үзэж,

* ***дүү лүгээ бээн*** - *дүүтэйгээ*
* ***иргэн*** - *"МНТ"-д "иргэн" хэмээх үг хүмүүс, албат олон, улс аймаг зэргийн өргөн утгаар тохиолдоно.*
* ***айсахыг*** - *наашлахыг, ирж явахыг*

6. өгүүлрүүн: "Тэд нүүж айсах иргэний дотор нэгэн харуутай* тэрэгний өлжигт* нэгэн охин сайн буюу хүмүүнээ эс өгтсөн* бөгөөс Добун мэргэн дүүдээн, чамд гуйя" хэмээж, Добун мэргэн дүү юүгээн үзэхээр* илгээв.

* ***харуутай*** - *хараа саравч бүхий бүрхүүлтэй тэрэг*
* ***өлжиг*** - *мухлаг тэргэний өмнөх, ид суудал*
* ***хүмүүнээ эс өгтсөн*** - *хүнд эс өгөгдсөн*
* ***дүү юүгээн үзэхээр***- *дүүгээ, тэр охиныг үзэхээр [явуулав.]*

7. Добун мэргэн тэд иргэнд хүрвээс, үнэнхүү гоо сайн, алдар нэр ихтэй, Алан гоо нэртэй, хүмүүнээ бээр өгтөөгүй* охин ажгуу.

* ***хүмүүнээ бээр өгтөөгүй*** - *хүнд ч өгөгдөөгүй, ураглаагүй*

8. Тэд бөлөг иргэн бээр* Хөл Баргужин төхөмийн эзэн Баргудай мэргэний охин Баргужин-гоо нэртэй охиныг, Хорь түмэдийн ноён Хорилардай мэргэнээ өгтсөн* ажгуу. Хорь түмэдийн газраа, Ариг уснаа Хорилардай мэргэний Баргужин-гоогоос төрсөн Алан-гоо нэртэй охин тэр.

***иргэн бээр**- *Иргэн хэмээх өгүүлэгдэхүүний тодлогч нь "бээр" юм. Эрт, дунд үеийн монгол хэл, ер нь монгол бичгийн хэлэнд түгээмэл тохиолдоно. Одоо ч "тэр бээр" гэх мэтээр хэрэглэж буй.*
***Хорилардай мэргэнээ өгтсөн**-*Хорилардай мэргэнд өгөгдсөн*

9. Хорилардай мэргэн Хорь түмэдийн газартаа булга, хэрэм гөрөөтэй газраан хориглолдож муулалдаж, Хорилар овогт болж, Бурхан халдуны гөрөөс гөрүүл сайт* газар, сайн хэмээн, Бурхан халдуны эзэд бурхан босгосон Шинчи баян Урианхайд нүүж айсун ажгуу. Хорь түмэдийн

Хорилардай мэргэний охин Ариг уснаа төрсөн Алан-гоог тэнд гуйж, Добун мэргэний авсан ёсон тийм.

* ***Гөрөөс гөрүүл сайт*** - *ан гөрөө сайтай*

10. Алан-гоо Добун мэргэнд ирж, хоёр хөвүүн төрүүлэв. Бүгүнүдэй, Бэлгүнүдэй нэртэн* бүлгээ.

* ***нэртэн***- *Дундад үеийн монгол хэлэнд үйлийн эзэн бие нь эр бол –т (-tu, -tь); эм бол –тай, тэй, той (-tai,-tei); олон тоотой бол –тан, тэн, тон (-tan, -ten) дагавар залгадаг. Жишээ нь: Бүгүнүдэй нэрт; Алан-гоо нэртэй; Бүгүнүдэй, Бэлгүнүдэй нэртэн гэх мэт.*

11. Дува сохор ах инү дөрвөн хөвүүт бүлгээ. Төдий атал Дува сохор ах инү үгүй болов.* Дува сохор үгүй болсны хойно, дөрвөн хөвүүд инү Добун мэргэн авга юүгаан үргаа үл болгон* доромжилж, хагацаж гээж* нүүв. Дөрвөн овогтон болж, Дөрвөн иргэн тэд болов.

* ***үгүй болов*** - *нас нөгчив.*
* ***үргаа үл болгон*** - *ураг төрөлд үл тооцон*
* ***хагацаж гээж*** - *салж орхиж*

12. Түүний хойно нэгэн өдөр Добун мэргэн Тогоцог өндөр дээр гөрөөлөхөөр гарав. Ой дотор Урианхадай хүмүүн чөх буга* алж, хавиргас ину, авид ину шарж бүхүйг золгож*,

* ***чөх буга*** - *гурван настай (гунан) буга*
* ***хавиргас ину, авид ину шарж бүхүйг золгож*** – *түүний авид, хавиргыг нь шарж байхад учирч*

13. Добун мэргэн өгүүлрүүн: "Нөхөр, шорлогд!*" хэмээжүхүй. Өгсү* хэмээж уушигт зүлд*, арьсыг ину авч, чөх бугын мах хөвчнийг* Добун мэргэнээ өгөв.

* ***Нөхөр, шорлогд !*** - *Нөхөр, ангийн хувь хишиг шорлог өг!*
* ***өгсү***- *өгье*
* ***уушигт зүлд*** - *алсан амьтны толгойг багалзуур, уушиг, зүрхтэй нь үргэлж авсан хэсэг. Агнасан хүн өөрөө авдаг учиртай.*
* ***бугын мах хөвчнийг*** – *бугын мах бүгдийг*

14. Добун мэргэн тэр чөх бугыг ачиж айсруун зуур* нэгэн яданги хүмүүн хөвүүгээ хөтөлж явахыг золгож*,

* ***айсруун зуур*** - *ирж явах замд*
* ***явахыг золгож*** - *явахтай учирч*

15. Добун мэргэн "Юун хүмүүн чи?" хэмээн асууваас, тэр хүмүүн өгүүлрүүн : "Би Маалиг Баягудай, ядаж явмуй. Тэр гөрөөсний махнаас надад өг. Би энэ хөвүүгээ чамд өгсү" хэмээжүхүй.

16. Добун мэргэн тэр үгэнд, чөх бугын өрөөл гуяыг ину хугалж өгч*, тэр хөвүүнийг ину авч ирж , гэр дотор зарж ахуу* бүлгээ.

* ***чөх бугын өрөөл гуяыг ину хугалж өгч*** - *чөх бугын өрөөсөн гуяыг нь тасалж өгч*
* ***ахуу*** – *байх*

17. Тийн атал Добун мэргэн үгүй болов. Добун мэргэнийг үгүй болсны хойно, Алан-гоо эр үгүй бөгөөд гурван хөвүүн төрүүлэв. Бугу Хатаги, Бухату Салжи, Бодончар мунхаг нэртэн бүлгээ.

18. Урьд Добун мэргэнээс төрсөн Бэлгүнүдэй Бүгүнүдэй хоёр хөвүүд ину Алан гоо эх юүгээн эчнээ* өгүүлэлдрүүн: "Энэ эх, бидний ах дүү, үе хаяа* хүмүүн үгүй, эр үгүй бөгөөтөл эд гурван хөвүүд* төрүүлэв. Гэр дотор гагц Маалиг Баягудай хүмүүн буюу. Эд гурван хөвүүд түүнийх буй зэ" хэмээн эх юүгээн эчнээ хэлэлдэхийг, Алан гоо эх ану ухаж*,

* ***эх юүгээн эчнээ*** - *эхийнхээ далд*
* ***үе хаяа хүмүүн*** - *үеэлид хаяалид хүмүүн*
* ***эд гурван хөвүүд*** - *Дундад үеийн монгол хэлэнд тодотгуулагч, тодотгогч нь ганц, олон тоогоор зохицдог байсан. Орчин цагийн монгол хэлэнд "Энэ гурван хөвүүн" хэмээн хэлж бичнэ.*
* ***эх ану ухаж*** – *тэдний эх мэдэж*

19. Хаврын нэгэн өдөр хонины хөншилмөл мах* чанаж, Бэлгүнүдэй, Бүгүнүдэй, Бугу Хатаги, Бухату Салжи, Бодончар мунхаг эд таван хөвүүдээн зэрэглэн* суулгаж, нижээл мөсдийг* "Хугалагтун" хэмээж өгөв. Нижээлийг юу байх, хугачиж ооров.* Бас таван мөсөд хамт цуглаж "Хугалагтун" хэмээж өгөв. Тавуул таван цугтай мөсдийг хүмүүн бүр барьж бидүүлж*, хугалан ядав.

* ***хонины хөншилмөл мах*** - *хонины хуршсан үүц мах*
* ***зэрэглэн*** - *зэрэгцүүлэн*
* ***нижээл мөсдийг*** - *нэг нэг сумны модыг*
* ***ооров***- *орхив, хаяв*
* ***бидүүлж***- *тойруулж, хэсүүлж*

20. Тэнд Алан-гоо эх ину өгүүлэв: "Та нар Бэлгүнүдэй, Бүгүнүдэй хоёр хөвүүд минь намайг эд гурван хөвүүдийг төрүүлэв. Хэний юуны хөвүүд буюу хэмээн сэрэлдэн* хэлэлдмүй. Сэрэхүй бээр таны зөв*.

* ***сэрэлдэн*** - *хардаж сэрдэлдэн*
* ***Сэрэхүй бээр таны зөв*** - *Сэжиглэх чинь та нарын зөв.*

21. Шөнө бүр цэгээн шар хүмүүн гэрийн өрх, тотгын гэгээгээр орж, хэвэлийг минь илж, гэгээн ину хэвэлд минь шингэх бүлгээ. Гарахдаа, наран сарны хилээр* шар нохой мэт шазвалзаж гарах бүлгээ. Дэмий яахан өгүүлэх, та нар. Түүгээр ухваас*, тэмдэг ину тэнгэрийн хөвүүд буюу зэ.

Хар тэргүүт хүмүүнд
Ханилган* яахан өгүүлэх, та нар
Хамгийн хаад болбоос
Харцас тэнд ухах, зэ." хэмээв.

* ***Наран сарны хилээр*** – *үүр шөнийн заагаар*
* ***ухваас*** - *мэдвээс, шинжилвээс, бодвоос*
* ***ханилган*** - *ханьсган, адилтган*

22. Бас Алан-гоо таван хөвүүддээн сүюгэр үг* өгүүлрүүн: "Та нар, таван хөвүүн, миний гагц хэвлээс төрөв. Та нар тугаарын* таван мөсөд мэт гагц гагц болбоос, тэр нижээл мөсөд мэт хэнээ бээр* хялбар хугалагдах*, та нар.

Тэр цугтай мөсөд* мэт хамт нэгэн эетэн* болбоос, хэнээ бээр хялбар яахан болох, та нар" хэмээв. Тийн атал Алан гоо эх ану* үгүй болов.

* ***сүюгэр үг*** - *соён сурган хэлэх сургаал үгс*
* ***тугаарын*** - *саяын*
* ***хэнээ бээр*** - *хэнд ч*
* ***хугалагдах*** - *дийлдэх*
* ***цугтай мөсөд*** - *багцалж боосон сумны таван мөс мод*
* ***нэгэн эетэн*** – *нэгэн санаатан*
* ***эх ану*** – *тэдний эх*

23. Эх юугээн, Алан гоог үгүй болсны хойно ах нар дүү нар тавуулаа адуусан, идээн* юугээн хуваалдахдаа, Бэлгүнүдэй, Бүгүнүдэй, Бугу Хатаги, Бухату Салжи дөрвүүл авалцав. Бодончарт, мунхаг бядуу буюу хэмээн урагаа ул тоон* хувь эс өгөв.

* ***адуусан, идээн*** - *мал хөрөнгө гэсэн утгатай тогтсон хэлц үг*
* ***урагаа ул тоон*** – *ураг төрөлд эс тооцон*

24. Бодончар урагаа эс тоогдож, "Энд атал юун!" хэмээж, гол дайрт годил сүүлт орог шунхлыг унаж, "Үхвээс инү үхсүгэй, аваас инү асугай*" хэмээж Онон мөрөн уруу зорчиж тавив*. Зорчиж, Балжун арал хүрч, тэнд өвсөн нэмбүүл гэр хийж, тэнд байж суув.

* ***Аваас инү асугай*** - *Байваас байсугай; амьдарваас амьдарсугай.*
* ***зорчиж тавив*** - *давхиж одов*

25. Тийн ахуйдаан борогчин харцгай* хар хур* барьж идэн бүхүйг үзэж, гол дайрт годил сүүлт орог шунхлын хялгасаар урхилж барьж, асрав.

* ***борогчин харцгай*** - *эм бор харцага*
* ***хар хур*** - *харавтар зүстэй гургуул*

26. Идэх идээн үгүй байхдаа, чонын гуунд хоргоосон гөрөөсийг мярааж харваж алж идээд, чонын идсэнийг тэмгэж* идээд, өөрийн хоолойдоо*, харцгайгаан бээр* тэжээсээр тэр он гарав.

* ***тэмгэж*** - *түүж*
* ***өөрийн хоолойдоо*** - *өөрийн ходоодоон; өөрийн гэдэсээн. Эртний монгол хэлэнд "хоолой" гэдэг үг "хоол, ходоод, гэдэс" гэх мэт олон утгыг илтгэж байсан.*
* ***харцгайгаан бээр*** - *харцгайгаан ч*

27. Хавар болов. Нугад ирэхүй* цагт харцгайгаан тийлүүлж ооров*.

Нугад галуудыг
Хожуул тутам хоншуун*
Үнжүүл* тутам үншүүн*
Үнэр үнэрттэл тавив.

* ***нугад ирэхүй*** - *нугас шувууд ирэхүй*
* ***тийлүүлж ооров*** – *сойж тавив*
* ***үнжүүл*** - *модны хувхай үндэс ёзоор*
* ***хоншуун, үншүүн***- *ялзарч үмхийрснээс гарах үнэр танар*

28. Дүйрэн (уулын) хэрүүгээс* Түнхэлиг горхи уруу бөлөг иргэн нүүж ирэв. Бодончар тэд иргэнд, харцгайгаан ороод* одож, өдөр эсэгчилж*, шөнө өвсөн нэмбүүл гэртээн ирж хонох бүлгээ.

* ***хэрүү*** - *уулын арын хүүшид ургасан шугуй*
* ***харцгайгаан ороод*** – *харцгайгаан орхиод*
* ***эсэг*** - *айраг цэгээ;* ***эсэгчилж***- *айраг цэгээ ууж*

29. Тэд иргэн, Бодончарын харцгайг гуйваас эс өгөв. Тэд иргэн Бодончарыг "Хэнийх буй, юуных буй?" хэмээн асуух үгүй, Бодончар бээр тэд иргэнийг "Юун иргэн?" хэмээн асуулцах үгүй явцгаав.

30. Бугу Хатаги ах ину Бодончар мунхаг дүү юугээн энэ Онон мөрөн уруу одлоо хэмээн эрэн ирж, Түнхэлиг горхин уруу нүүж ирсэн иргэнээс "Тийм хүмүүн, тийм морьт бүлгээ" хэмээн сурваас,

31. тэд иргэн өгүүлрүүн: "Хүмүүн бээр, морин бээр* чиний сурахад адил буюу. Тэр хүмүүн харцгайт зэ буюу.

Өдөр бүр манд ирж* эсэгчилж одмуй. Шөнө магад хаа хонох ажгуу? Өрнө умраас хий болбоос*, харцгайгаар бариулсан нугад, галуудын өдөн үсэн ану бургалиг цас мэт бутарч хийсч ирмүй. Энд ойр буюу зэ. Эдүгээ ирэх цаг болов. Хоромхон хүлц!" хэмээв.

* ***хүмүүн бээр, морин бээр*** *- хүн нь ч, морин нь ч*
* ***манд ирж*** *- бидэнд ирж*
* ***Өрнө умраас хий болбоос*** *- баруун хойноос салхи салхилбаас*

32. Хором атал, Түнхэлиг горхи өөд нэгэн хүмүүн айсун буюу. Хүрч ирвээс, Бодончар мөн ажгуу. Бугу Хатаги ах ину үзээд, таньж аваад, удирдаж* Онон мөрөн өөд хатируулан зорчиж тавив*.

* ***удирдаж*** *- дагуулж*
* ***зорчиж тавив*** *– давхиж одов*

33. Бодончар Бугу Хатаги ах юугаан* хойноос дагаж, хатирч явж өгүүлрүүн: "Ах! Ах! Бие тэргүүт, дээл захт сайн" хэмээв. Ах ину, Бугу Хатаги тэр үгийг ину юунаа бээр эс болгов*.

* ***ах юугаан*** *- ахынхаа*
* ***юунаа бээр эс болгов*** *- юунд ч эс хайхрав, ер хэрэгссэнгүй*

34. Бас мөн үг өгүүлбээс, ах ину юунаа бээр* үл болгон, харiу ину эс дуугарав. Бодончар явж, бас мөнхүү үг өгүүлэв. Тэр үгэнд ах ину өгүүлрүүн: "Тугаараас* мөн мөн* юун үг өгүүлмү, чи" хэмээв.

* ***юунаа бээр*** *- юунд ч*
* ***Тугаараас*** *- саяхнаас*
* ***мөн мөн*** *- бас бас, дахин дахин*

35. Тэндээс Бодончар өгүүлрүүн: "Тугаарын Түнхэлиг горхиноо бүхүй иргэн их өчүүхэн, муу сайн, тэргүү шийр үгүй*, сацуун буй. Хялбар иргэн буй. Бид тэднийг агуулья*" хэмээв.

* ***тэргүү шийр үгүй*** *- эх адаггүй, хөл толгой үгүй, ээзнгүй*
* ***агуулья*** *- эзэлж авч, эзэн болъё*

36. Тэндээс ах ину өгүүлрүүн: "Зэ, тийн бөгөөс гэртээн хүрч, ах нар дүү нар эетэлдэж* тэд иргэнийг агуулъя" хэмээлдэж,

* ***ах нар дүү нар эетэлдэж*** *- ах дүү нар зөвшилдөж*

37. гэртээн хүрээд, ах нар дүү нар хэлэлдэж*, морилов*. Мөн Бодончарыг алгинч агуулгав*.

* ***хэлэлдэж*** *- хэлэлцэж*
* ***морилов*** *- Дундад үеийн монгол хэлэнд "морилох" хэмээх үг хүндэтгэлийн утгагүй бөгөөд "явах, мордох" хэмээсэн ерийн утгатай болой.*
* ***алгинч агуулгав*** *- толгойн туршуул болгон довтолгов.*

38. Бодончар алгинч агуулж, нэгэн думд хээлтэй* эмийг барьж, "Чи юужин хүмүүн?*" хэмээн асуув. Тэр эм өгүүлрүүн: "Би Жарчууд Аданхан Урианхажин*" хэмээв.

* ***хээлтэй*** *- жирэмсэн; дундад үеийн монгол хэлэнд "жирэмсэн, хөл хүнд" хэмээхийг "хээлтэй" хэмээдэг байжээ.*
* ***Чи юужин хүмүүн?*** *- Чи юун хүн? (-жин) эм хүйс зааж байсан дагавар.*
* ***Урианхажин*** *- урианхай овгийн эм хүмүүн.*

39. Тэд иргэнийг ах, дүү тавуул дагуулиж*, адуун, идээнээ*, аран* тутхараа* байхуй суухуйд хүрэв.

* ***дагуулиж*** *- булаан авч, олзлон эзэлж*
* ***адуун идээнээ*** *- мал хөрөнгөнд гэсэн тогтсон хэлц үг*
* ***аран*** *- хүмүүн, хүмүүс хэмээсэн утгатай. Энэ үгэнд олон тооны "-д" дагавар залгасан ард хэмээх үг одоо идэвхтэй хэрэглэгдэж буй. Хойшид олонтаа тохиолдох тул "хүмүүн" хэмээж хөрвүүлэв.*
* ***тутхараа*** *- зарц боолд нь; **аран тутхар** хэмээх нь тогтсон хэлц үг байжээ.*

40. Тэр думд хээлтэй эм Бодончарт ирж хөвүүн төрүүлэв. "Жад* иргэний хөвүүн бүлгээ" хэмээн Жажирадай нэрийдэв. Жадараны өвөг тэр болов. Тэр Жажирадайн хөвүүн Түгүүдэй нэрт бүлгээ. Түгүүдэйн хөвүүн Бүри Булчиру бүлгээ. Бүри Булчиругийн хөвүүн Хар Хадаан бүлгээ. Хар Хадааны хөвүүн Жамуха бүлгээ. Жадаран овогтон тэд болов.

* ***Жад*** *– харь*

41. Тэр эм бас Бодончараас нэгэн хөвүүн төрүүлэв. “Барьж авсан эм бүлгээ” хэмээн тэр хөвүүнийг Бааридай нэрийдэв. Баарины өвөг тэр болов. Бааридайн хөвүүн Чидухул бөх. Чидухул бөх эмс олонт бүлгээ. Хөвүүн инү мэнэ* мэт төрөв. Мэнэн Баарин овогтон тэд болов.

** **мэнэ** - элбэг олон, маш олон*

42. Бэлгүнүдэй, Бэлгүнүд овогтон болов. Бүгүнүдэй Бүгүнүд овогтон болов. Бугу Хатаги, Хатагин овогтон болов. Бухату Салжи, Салжууд овогтон болов. Бодончар, Боржигин овогтон болов.

43. Бодончарын авааль эмээс төрсөн Барим Шийрт Хабичи нэрт бүлгээ. Тэр Хабичи баатарын эхийн инжид* ирсэн эмийг Бодончар татаж бүлгээ*. Нэгэн хөвүүн төрөв. Жэгүрэдэй нэрт бүлгээ. Жэгүрэдэй урьд зүхэлд* орон бүлгээ.*

** **инж** - бэр буулгахад дагалдах өмч хөрөнгө, зарц албат*
** **татаж бүлгээ** – татвар эм болгосон билээ*
** **зүхэл** - зүлдээр тайх тахилга тайлга.*
** **Жэгүрэдэй урьд зүхэлд орон бүлгээ** - Бодончарыг амьд байхад, Жэгүрэдэй үл гадуурхагдан, зүхэл тайлгад оролцдог байжээ.*

44. Бодончарыг үгүй болсны хойно, тэр Жэгүрэдэйг “гэр дараа* Аданхан урианхадай хүмүүн байлаа. Түүнийх буй зэ” хэмээж зүхлээс гаргаж*, Жэгүрэйд овогт болгожухуй. Жэгүрэйдийн өвөг тэр болов.

** **гэр дараа** - гэрт үргэлж байгч*
** **зүхлээс гаргаж** - дээдсийг тахиж тайх тайлгад оролцуулахаа больж*

45. Хабичи баатарын хөвүүн Мэнэн Тудун бүлгээ. Мэнэн Тудуны хөвүүн Хачи Хүлүг, Хачин, Хачигу, Хачула, Хачигун, Харалдай, Начин баатар долоон бүлгээ.

46. Хачи Хүлүгийн хөвүүн Хайду, Номулун эхээс төрсөн бүлгээ. Хачины хөвүүн Ноёгидай нэрт бүлгээ.

Ноёмсог авирт тул Ноёхон овогтон болов. Хачигугийн хөвүүн Баруладай нэрт бүлгээ. Их биет, идээн барах бүлгээ. Барулас овогтон болов. Хачулагийн хөвүүн идээн барах тул Их Барула, Өчүүхэн Барула нэрийдэж, Барулас овогтон болгож, Эрдэмт Барула, Төдөгэн Барула тэргүүтэн Барулас тэд болов. Харалдайн хөвүүд будаан хутгалах, эх, түрүү үгүй тул Будагад овогтон тэд болов. Хачигуны хөвүүн Адархидай нэрт бүлгээ. Ах дүү зуур адрагч тул Адархин овогтон болов. Начин баатарын хөвүүд Уругудай, Мангудай нэртэн бүлгээ. Уругуд, Мангуд овогтон тэд болов. Начин баатарын авааль эмээс төрсөн Шижуудай, Доголадай нэртэн бүлгээ.

47. Хайдугийн хөвүүд Бай Шинхор Догшин, Чарахай Линху, Чаужин Өртэгэй гурван бүлгээ. Бай Шинхор Догшины хөвүүн Тумбинай Сэцэн бүлгээ. Чарахай Линхугийн хөвүүн Сэнгүм Билгэ, Амбагайтан* Тайчууд овогтон болов. Чарахай Линхугийн бэргэн эмээс төрсөн Бэсүдэй нэрт бүлгээ. Бэсүд овогтон тэд болов. Чаужин Өртэгэйн хөвүүд Оронар, Хонхотан, Арулад, Сөнид, Хабтурхас, Гэнигэс овогтон тэд болов.

** **Амбагайтан** - Амбагай тэргүүтэн*

48. Тумбинай Сэцэний хөвүүн Хабул хаан, Сэм Сэчүлэ хоёр бүлгээ. Сэм Сэчүлэгийн хөвүүн Бүлтэчү баатар бүлгээ. Хабул хааны хөвүүд долоон бүлгээ. Анх их инү* Охин Бархаг, Бартан баатар, Хутугту Мөнгүр, Хутула хаан, Хулан, Хадаан, Төдөгэн Отчигин эд долоон бүлгээ.

** **Анх их инү** - ууган нь*

49. Охин Бархагийн хөвүүн Хутугту Жүрхи бүлгээ. Хутугту Жүрхийн хөвүүд Сэчэ* бэхи, Тайчу хоёр бүлгээ. Жүрхи овогтон тэд болов.

** **Сэчэ** - “МНТ”-ны бусад хэсэгт “Сача” хэмээсэн байдаг. Лувсанданзаны “Алтан товч”-д “Сэцэн” хэмээсэн болой.*

50. Бартан баатарын хөвүүд Мэнгэтү хиан, Нэхүн тайш, Есүхэй баатар, Даайридай Отчигин эд дөрвөн бүлгээ. Хутугту Мөнгүрийн хөвүүн Бүри бөх бүлгээ. Ононы түнд хуримлахуйд*, Бэлгүдэйн мөрийг хангас цавчсан* тэр бүлгээ.

**Ононы түнд хуримлахуйд* - *Ононы битүү шугуйд найрлахад*

** **хангас цавчсан*** - *хага цавчсан*

51. Хутула хааны хөвүүд Жочи, Гирмагу, Алтан гурван бүлгээ. Хулан баатарын хөвүүн Их Чэрэн бүлгээ. Бадай Хишилиг хоёр дархадын ноён тэр бүлгээ. Хадаан Төдөгэн хоёр ураг үгээгүүн* бүлгээ.

** **Ураг үгээгүүн*** - *[тэд] үр хүүхэдгүй.*

52. Хамаг Монголыг Хабул хаан мэдэн байв. Хабул хааны хойно, Хабул хааны үгээр долоон хөвүүдээн бөгөөтөл, Сэнгүм Билгэ-гийн хөвүүн Амбагай хаан, Хамаг Монголыг мэдэн байв.

53. Буйр нуур, Хөлөн нуур хоёрын зуур Оршуун мөрнөө бүхүйн Айригууд, Буйругууд Татаар иргэнээ, Амбагай хаан охин өгч, өөсөөн* охиноо үдэж одох болон, Татаар Жүйн иргэн Амбагай хааныг барьж, Хятаны Алтан хаанд авч одохуйд, Амбагай хаан Бэсүдэй хүмүүнээ Балахачи элчнээр өгүүлж илгээрүүн: "Хабул хааны долоон хөвүүдийн думдад Хутулад өгүүл. Миний арван хөвүүдийн дотор Хадаан тайшид өгүүл" хэмээн өгүүлж илгээхдээ,

"Хамгийн хаан, улсын эзэн болж, охиноо өөсөөн* үдэхээ намаар* гэсгээгтүн*! Татаар иргэнд баригдаа, би. Таван хуруудынхаан хумс Тамтартал Арван хуруудаан Хуурталч Ачийг минь авран* сориггүн" хэмээж илгээжүхүй.

** **өөсөөн*** – *өөрөөн*
** **намаар*** - *надаар*
** **гэсгээгтүн!*** – *цээрлэл болгогтүн!*
** **ачийг минь авран*** – *өсийг минь аван*

54. Тэр цагт Есүхэй баатар Онон мөрнөө шувуулан явахуйд*, Мэргэдийн Их Чилэдү Олхунууд иргэнээс охин авч үүсгэж айсахуйг золгож*, тэргэнд инү өнгийж үзвээс, өнгө зүс бустай*, охин хатаныг үзэж, гэртээн харин довтолгож, Нэхүн тайш ах юугаан, Даайридай Отчигин дүүгээн удирдаж* иржүхүй.

** **шувуулан явахуйд*** - *шонхор, харцгайгаар ан хийн явахад,*
** **айсахуйг золгож*** - *харьж явахтай таарч,*
** **өнгө зүс бустай*** - *ер бусын гоо өнгө зүстэй*
** **дүүгээн удирдаж*** - *дүүгээн дагуулж*

55. Хүрэхүй лүгээ, Чилэдү айжухуй. Тэр хурдан хүл хувт ажгуу. Хүл хув юугаан гуяыг ину дэлдэж*, гувир намбалис буруулахуй лугаа*, хойноос ину гурвуул удааралдав*. Чилэдү хошуу хучлас харьж*, тэргэндээн ирэхүй лүгээ, тэнд Өгээлүн үжин өгүүлрүүн: "Тэд гурван хүмүүнийг ухав уу, чи. Царай, царайгаас бус буй. Аминд чинь хүрэхүй царайтан буй.

Амин чинь л бөгөөс
Өлжиг* тутам охид
Харуу* тутам хатад буй.

Амин чинь л бөгөөс, охин хатан олъюу зэ, чи. Бус нэртийг бас Өгээлүн нэрийдьюу зэ, чи. Амиа хорго! Үнэрийг минь үнсч* яв" хэмээн цамцаан мүлтэлж, морин дээрээс налсхийж авахуй лугаа, гурвуул хошуун хучилдаж*, хүрч айсахуй лугаа, Чилэдү хурдан хувын гуяыг ину дэлдэж, зухас дутааж*, Онон мөрөн өөд дутаав.

** **гуяыг ину дэлдэж*** - *ташуурдаж*
** **гувир намбалис буруулахуй лугаа*** - *гувээ толгойг даван дутаахад*
** **удааралдав*** - *дараалалдан, цувралдан [нэхэв.]*
** **[хошуу] хучлас харьж*** - *хошуу тойрон буцаж*

* ***Өлжиг*** - *өлжигтэй тэрэг*
* ***харуу*** - *харуутай тэрэг*
* ***үнсч***- *Монгол бичгээр үнэр, үнсэх хэмээх үгийг "үнүр, үнүсху" гэж бичдэг. Эдгээр үгийн гарал нэг бөгөөд "үнсч" гэх нь үнэрлэж хэмээсэн утгатай буй.*
* ***хошуун хучилдаж*** - *хошуу тойрцгоож*
* ***зухас дутааж*** - *ам мөлтөс дутааж*

56. Гурвуул хойноос ину нэхэж, долоон гувир давтал үлдэж, харьж ирж, Өгээлүн үжинийг Есүхэй баатар дэлбэгнээс* хөтөлж, Нэхүн тайш ах ину удирдаж, Даа(а)ридай Отчигин дүү ину гэрэгний ялуу* зэрэгцэж айсахуйд, Өгээлүн үжин өгүүлрүүн:

"Ах минь, Чилэдү
Хий өөд
Хөхлөөн хийсгэсээр
Хээр газраа
Хэвлээн өлсгөсөөр бүлгээ.

Эдүгээ хэр л хоёр шивэргэлээн* нэгэнтээ ар дээрээн оорч, нэгэнтээ өвөр дээрээн оорч, нэгэнтээ урагшид, нэгэнтээ хойногшид хэр л хийж одмуй" хэмээгээд
Онон мөрнийг долгистол
Ой жубур* дуурстал их дуугаар уйлж айсахуйд, Даа(а)ридай Отчигин зэрэгцэж явж өгүүлрүүн:

" Даварих* эр чинь
Давааолныг давав.
Уйлуулах эр чинь
Ус олныг гэтлэв.
Хайлж хашгирваас
Халайж* үл үзэх, чамайг
Хайж эрвээс
Хаалгыг* ину үл олох, чи
Сэм боль"

хэмээж ятгав. Өгээлүн үжинийг, Есүхэй төдий гэртээн авч ирэв. Өгээлүн үжинийг Есүхэйн авч ирсэн ёсон тийм.

* ***дэлбэг*** - *тэрэг залах жолоо*
* ***ялуу*** - *тэрэгний арал*
* ***шивэргэл*** - *олон нарийн гөрж, ар өвөр тийш унжуулсан үс*
* ***жубур***- *ой шугуйт уулын хөндий, зав жалга*
* ***даварих*** - *учрах, тохиох.*
* ***халайж*** – *харж*
* ***хаалгыг*** - *зам мөр*

57. Амбагай хааны, Хадаан, Хутула хоёрыг нэрийдэж илгээснээр, Хамаг Монгол, Тайчууд Ононы Хорхонаг жубурт хурж, Хутулыг хаан болгов. Монголын жаргалан дэвсэн, хуримлан жаргах бүлгээ. Хутулыг хан өргөөд, Хорхонагийн саглагар мод гойрон орчиж
Хавиргандаа
Хуулга болтол
Өвдгөндөө
Өлхөг* болтол дэвсэв.

* ***өлхөг***- *шороо, тоос*

58. Хутула хаан болоод, Хадаан тайш хоёр Татаар иргэнд морилов. Татаарын Хөтөн Бараха, Жали Буха хоёрт арван гурвантаа хатгалдаж,
Амбагай хааны
Өшил өшин
Хясал хясан ядав.

59. Тэнд Есүхэй баатар Татаарын Тэмүжин Үгэ, Хори Буха тэргүүтэн Татаарыг дагуулиж* ирвээс, тэнд жирэмсэн байсан* Өгээлүн үжин Ононы Дэлүүн болдогт бүхүйд, зөв тэнд* Чингис хаан төржүхүй. Төрөхүйд, баруун гартаан шаан чинээ* нөжин атган төржүхүй. Татаарын Тэмүжин Үгэг авч ирсэнд төрөв хэмээн Тэмүжин нэр өгөхүй тийм.

* ***дагуулиж*** – *булаан авч, олзлон эзэлж*
* *жирэмсэн байсан хэмээхийн оронд "МНТ"-нд "хээлтэй бүрүүн" гэж буй. Их эзний хатан ээжийг хүндлэхийн учир хөрвүүлэгч би эерүүлэн сольж найруулав.*
* ***зөв тэнд*** - *яг тэнд*
* ***шаан чинээ*** - *шагайн чинээ (шаант чөмөг гэвэл шагайтай чөмгийг хэлдэгтэй адилтгаж болно)*

60. Есүхэй баатарын Өгээлүн үжинээс Тэмүжин, Хасар, Хачигун, Тэмүгэ эд дөрвөн хөвүүд төрөв. Тэмүлүн нэртэй нэгэн охин төрөв. Тэмүжинийг есөн наст бүхүйд, Жочи Хасар долоон наст бүлгээ. Хачигун Элчи таван наст бүлгээ. Тэмүгэ Отчигин гунан* бүлгээ. Тэмүлүн өлгийтэй бүлгээ.

** **гунан** - гурван настай (Орчин цагийн монгол хэлэнд эр амьтны гурван настайг нэрийдэх болжээ. Туульд гарах "Гунан Улаанбаатар" хэмээхтэй адилтган үз)*

61. Есүхэй баатар Тэмүжинийг есөн наст бүхүйд, Өгээлүн эхийн төрхөм Олхунууд иргэнд, нагац нараас ину охин гуйсу хэмээн Тэмүжинийг аваад зорчив. Одохуйд, Цэгцэр Чихургу хоёрын зуур Хонгирадын Дэй сэцэн лүгээ золгов*.

** **золгов** – уулзав, таарав*

62. Дэй сэцэн өгүүлрүүн: "Есүхэй худ хэнд зорьж айслаа*?" хэмээжүхүй. Есүхэй баатар өгүүлрүүн: "Энэ хөвүүний минь нагац нар Олхунууд иргэнд охин гуйсу хэмээн айслаа.*" хэмээжүхүй. Дэй сэцэн өгүүлрүүн:

"Энэ хөвүүн чинь
Нүдэндээн галт
Нүүрэндээн гэрэт* хөвүүн буй."

** **айслаа** – нааш явлаа, ирлээ*
** **гэрэ** - гэрэл; гэрэт-гэрэлт*

63. Есүхэй худ би энэ шөнө зүүд зүүдлэв. Цагаан шонхор наран, сар хоёрыг атган нисч ирж гар дээр минь туув*. Энэ зүүдээн хүмүүнээ өгүүлрүүн: Наран, сарыг харж, үзэгдэн бүлгээ. Эдүгээ энэ шонхор атгаж авчирч, гарт минь туув. Цагаан буув. Ямар л сайн үзүүлмүй хэмээлээ. Есүхэй худ, энэ зүүдэн минь чамайг л хөвүүнээ удирдаж ирэхүйеэ үзсэн ажгуу. Зүүд сайн зүүдлэв.

Юун зүүд байх! Та нар, Хиад иргэний сүлдэр* ирж заасан ажгуу.

** **туув** - суув (шувуу юман дээр суухыг ийн өгүүлдэг.)*
** **сүлдэр** – сүлд, онгон, цалиг*

64. Бид Хонгирад иргэн эрт өдрөөс
Зээгийн зүс
Охины өнгөтөн.
Харь улсыг үл тэмцэн*,
Хацар гоо охидыг
Хаан болсон та нарын
Хасаг тэргэнд* унуулж*
Хар буур хөлгөж
Хатируулж одож
Хатан сууринд
Хамт суулгамуй, бид.
Улс иргэнийг үл тэмцэн,
Өнгө сайд* охидоон өсгөж
Өлжигтэй тэргэнд унуулж*
Өл буур хөлгөж
Үүсгэж одож
Өндөр сууринд
Өрөөл этгээдэд суулгахуй, бид.

Эртнээс Хонгирад иргэн

Хатан халхтан
Охид өчилтэн
Зээгийн зүс
Охины өнгөөр бүлгээ, бид.

** **харь улсыг үл тэмцэн** - бусад улсад үл халдан*
** **хасаг тэргэг** - тэнхлэгээрээ эргэдэг богинохон хүрдтэй тэргэ*
** **хасаг тэргэнд унуулж** - хасаг тэргэнд суулгаж*
** **сайд** – сайны олон тоо*
** **Өлжигтэй тэргэнд унуулж** - өлжиг суудалтай тэргэнд суулгаж*

65. Нуган хөвүүд маань
Нутаг харъюу
Охин хөвүүн маань
Өнгө үзэгдьюу.

Есүхэй худ гэрт минь одъё. Охин минь өчүүхэн буюу. Худ үзтүгэй хэмээж, Дэй сэцэн гэртээн удирдаж буулгав.*

** **удирдаж буулгав** - дагуулж буулгав.*

66. Охиныг ину үзвээс
Нүүрэндээн гэрэтэй *(гэрэлтэй,хөр.)*
Нүдэндээн галтай охиныг үзэж,
Ойндоон оруулав.*

Тэмүжинээс нэгэн нас их, аравтай ажгуу. Бөртэ нэртэй ажээ. Шөнө хонож, манагаш* охиныг ину гуйваас, Дэй сэцэн өгүүлрүүн:

Олонтаа л гуйлгаж, өгвөөс дээжлэгдэх
Цөөнтээ л гуйлгаж, өгвөөс доромжлогдох.
Охин хүмүүний заяан төрсөн үүдэнд өтлөх үгүй.
Охиноо бээр* өгсү,
Хөвүүнээ бээр*
Хүргэдэд талбиж* од!

хэмээв. "За" бололцож, Есүхэй баатар өгүүлрүүн: "Хөвүүнээ хүргэдэд талбису. Хөвүү минь нохойноос цочимдуу бүлгээ. Худ хөвүүнийг минь нохойноос бүү цочуул" хэмээгээд, хөтөл мориор* бэлэг өгч, Тэмүжинийг хүргэдэд талбиж одов.

**ойндоон оруулав - сэтгэлдээ хадгалав, санаанд нь нийцэв*
** манагаш – маргааш*
** охиноо бээр – охиноо ч*
** хөвүүнээ бээр – хөвүүнээ ч*
**хүргэдэд талбиж – хүргэн болох хүнийг сориулахаар хадмын гэрт үлдээж*
** хөтөл мориор - хөтөлж явсан мориор, хөтөлгөө мориор*

67. Есүхэй баатар зуур Цэгцэрийн шар хээрт, Татаар иргэн хуримлан* бүхүйд золгож, ундаасч тэдний хуримд буув. Тэд Татаар танин ажгуу. "Есүхэй Хияан ирвэй" хэмээгээд урьдны дагуулигдсан* хорслоон дурдаж, өшлөлдөн хорлож, хор хольж өгчүхүй. Зуур муу одож, гурван хоног явж, гэртээн хүрээд муу болж,

** **хуримлан** - найрлан*
** **дагуулигдсан** – булаалган олзлогдсон*

68. Есүхэй баатар өгүүлрүүн: "Дотор минь муу буй. Дэргэд хэн буй" хэмээж, Хонхотадай Чараха өвгөний хөвүүн Мэнлиг ойр буй хэмээвээс, урьж ирүүлж, өгүүлрүүн: "Чага минь*, Мэнлиг! Хөвүүд өчүүхэд бүлгээ. Би хөвүүгээ, Тэмүжинийг хүргэдэд талбиж ирэхдээ, зуур Татаар иргэнээ өшлөгдлөө би. Дотор минь муу буюу. Өчүүхэн хоцрогсод дүү нараа, бэлбэсэн бэргэнээ асрахыг чи мэд. Хөвүүг минь, Тэмүжинийг үтэрхэн одож авчир. Чага минь, Мэнлиг!" хэмээгээд нөгчив.

****Чага минь** - хүү минь, балчир үр минь хэмээн энхрийлсэн үг. (Зарим нутагт "чаха" хэмээн өгүүлдэг буй.)*



Хоёрдугаар бөлөг

69. Есүхэй баатарын үгийг бус үл болгон, Мэнлиг одож, Дэй Сэцэнээ өгүүлрүүн: "Есүхэй ах, Тэмүүжинийг маш мөрөөлж, өрөөн өвдмүй.* Тэмүүжинийг авахаар ирэв" хэмээжүхүй. Дэй сэцэн өгүүлрүүн: "Худ хөвүүгээ мөрөөлөх бөгөөс одтугай. Үзэж, үтэр иртүгэй" хэмээж, Мэнлиг эцэг* Тэмүүжинийг авч ирэв.

** **маш мөрөөлж, өрөөн өвдмүй** - маш их мөрөөдөж, өрөвдмүй.*

** **Мэнлиг эцэг** - "МНТ"-ны зохиогч бээр хэлж заншсанаараа "Мэнлиг эцэг" хэмээн бичжээ. "Мэнлиг эцэг" хэмээх нь энэ цаг үед үл зохилдоно.*

70. Тэр хавар Амбагай хааны хатад Өрбэй, Сохатай жирин* ихсээ газраа тавиг тайлга гаргасанд, Өгээлүн үжин одож хожид хүрч*, хожимдуулсан Өрбэй, Сохатай хоёрт Өгээлүн үжин өгүүлрүүн: "Есүхэй баатарыг үхэв үү хэмээж, хөвүүдийг минь их үл болоогүй тул ихсийн хишгээс, билүүрээс*, сархадаас яахан хождуулмуй, та нар.

Үзээд идэхүй

Үл сэргүүлэн нүүхүн* болов, та нар" хэмээжүхүй.

** **Өрбэй, Сохатай жирин** - Өрбэй, Сохатай хоёр.*

Дундад үеийн монгол хэлэнд эм хүйсэнд "жирин" эр хүйсэнд "хоёр" хэмээх үгийг хэрэглэдэг байв. Хойшид зөвхөн хоёр хэмээж бичив.

** **хожид хүрч** - хожимдон очиж*
** **билүүр** - тахилгын идээ шүүс*
** **үзээд идэхүй үл сэргүүлэн нүүхүн**- үзүүлж байгаад идэх, унтаагаар орхин нүүх*

71. Тэр үгэнд Өрбэй Сохатай хоёр хатан өгүүлрүүн:

Урьж үл өгтөх мөртэй*, чи
Учирваас идэх ёстой, чи
Хүргэж үл өгтөх мөртэй, чи

Хүртвээс идэх ёстой, чи
Амбагай хааныг үхэв үү хэмээж, Өгээлүнээ хүртэл ийн хэмээгдэхүй болов.

** **үл өгтөх мөртэй** - үл өгөгдөх жамтай*

72. "Аргац! Эднийг, Эхэс, хөвүүдийг, нутагт гээж нүүгтүн! Та нар бээр* бүү авч явагтун" хэмээгээд манагарш* өдрөөс Тайчуудын Таргудай Хирилтуг, Төдөгэн Гиртэтан* Тайчууд Онон мөрөн уруу хөдлөв. Өгээлүн үжинийг, эхэс хөвүүдийг гээж нүүх үед, Хонхотадай Чараха өвгөн одож ятгахад, Төдөгэн Гиртэ өгүүлрүүн:

"Цээл усан тасарлаа.
Цэгээн чулуу цуурлаа."

хэмээгээд нүүжүхүй. Чараха өвгөнийг "Чи хэр ятгах" хэмээн жадаар зоо гудас* хатгажухуй.

** **та нар бээр** - та нар ч*
** **манагарш** - маргааш*
** **Төдөгэн Гиртэтан** - Төдөгэн Гиртэтан тэргүүтэн*
** **зоо гудас** - зоо нуруу дагуу*

73. Чараха өвгөн шархт болж, гэртээн ирж, бэрх хэвтэхүйд* Тэмүжин үзэхээр оджухуй. Тэнд Хонхотадай Чараха өвгөн өгүүлрүүн: "Сайн эцгийн чинь хураасан улсыг, манай бүх улсыг авч нүүхэд, тэднийг ятгах болон ийн хийгдэв" хэмээжүхүй. Түүнд Тэмүүжин уйлаад гарч одов. Өгээлүн Үжин гээж нүүх үед туглаж*, биеэр морилж, зарим иргэнийг няцаав*. Тэд бээр няцаагдсан иргэн* үл тогтон, Тайчуудын хойноос нүүжүхүй.

** **бэрх хэвтэхүйд** - ихэд зовиурлан хэвтэхүйд*
** **туглаж** - туг барьж*
** **зарим иргэнийг няцаав** - зарим иргэнийг буцаав*
** **Тэд бээр няцаагдсан иргэн** - буцаан авчирсан тэд иргэн*

74. Тайчууд ах дүү Өгээлүн үжинийг, бэлэвсэнийг, хөвүүд өчүүхэд, эхэс хөвүүдийг* нутагт гээж нүүжүхүй.

Өгээлүн үжин эм мэргэн төрж

Өчүүхэн хөвүүдээн тэжээхдээ
Өхийтөл богтолж*,
Өгчийтэл бүсэлж*
Онон мөрний өөд уруу гүйж
Олирс, мойлс тэмгэж
Өдөр, шөнө хооллон тэжээв.
Сөстэй* төрсөн Үжин эх
Суутан хөвүүдээн тэжээхдээ,
Чигүүрсэн шор* барьж
Сөд, гичгэнэ ухаж тэжээв.
Эх үжиний
Халиар мангираар тэжээсэн хөвүүд
Хаад болохуйд хүрэв.
Зарчимтай Үжин эхийн
Затгас* төмсөөр тэжээсэн хөвүүд
Засагтан сэцэд болов.

**эхэс хөвүүдийг* - Сүчигэл эх, Бэгтэр Бэлгүүдэй нарыг зааж байгаа бололтой*
** **өхийтөл богтолж** - малгайгаа сайтар даран өмсөж*
** **өгчийтэл бүсэлж** - дээлээ шуун, бүсээ чангалж*
** **сөстэй** – цөстэй, зоригтой*
** **Чигүүрсэн шор** - чөөрс модон шор*
** **затгас** - сараана цэцгийн үндэс, цагаан төмс*

75. Гоо Үжиний
Гогод мангираар тэжээсэн
Хатанги туранхай хөвүүд
Хутагтан сайд* болов.
Эрс сайд болон барж*
Эрхт омогтон бологдов.
Эх юүгээн тэжээе хэмээлдэж
Эх Ононы эрэг дээр сууж
Өлгүүр гөхий засалдаж
Эрэмдэг зэрэмдэг загасыг
Өлгөж, гөхийлж
Зүүгээр гөхий* матаж

Зэвэг, хадар гөхийлдөж*
Гөлми гувчуур* уяж
Жараахай загас шүүж
Жич эх юүгээн ачлан тэжээв.

* **сайд** - *сайн хэмээх үгийн олон тоо, сайчуул*
* **барж** - *төгсч, [эрийн цээнд] хүрч*
* **гөхий** - *гох, дэгээ бүхий загас агнах зэвсэг*
* **гөхийлдөж** - *гөхийгөөр загас барьцгааж*
* **гөлми гувчуур** – *урхи тор*

76. Нэгэн өдөр Тэмүжин, Хасар, Бэгтэр, Бэлгүдэй дөрвөн хамт сууж, гөхий татахуйд, нэгэн гэгээн сугусун* оржухуй. Тэмүжин Хасар хоёроос Бэгтэр Бэлгүдэй хоёр булааж авав. Тэмүүжин Хасар хоёр гэрт ирж, Үжин эхэд өгүүлрүүн: "Нэгэн гэгээн сугусун гөхий зуусныг Бэгтэр Бэлгүдэй ах дүү хоёрт булааж автав, бид" хэмээвээс, Үжин эх өгүүлрүүн: "Юун хэмээж, аҳ нар дүү нар яахан тийн хийлдмүй, та нар!

Сүүдрээс бус нөхөр үгүй
Сүүлнээс бус чичуга* үгүй

буй, бид. Тайчууд ах дүүгийн гашуун өс хэр (хэрхэн) авах бид хэмээж бүхүйд, эртний Алан-гоо эхийн таван хөвүүд мэт яахан эе үгээгүүн буй, та нар. Бүүтүгэй*!" хэмээв.

* **гэгээн сугусун** - *өнгөлөг алгана загас*
* **чичуга** - *ташуур*
* **Бүүтүгэй!** - *больтугай, байтугай, бүү тэг!*

77. Тэндээс Тэмүүжин Хасар хоёр үл таалан өгүүлрүүн: "Өчигөн* нэгэн удаа бялзуухай годилдсоныг* тийнхүү булааж авлаа. Эдүгээ бас тийнхүү булаав. Бид хамт хэр байхун" хэмээгээд үүдэн оорч, гарч одов. Бэгтэр улхан* дээр шарга агттан есөн морио харж, сууж бүхүйд Тэмүүжин умраас, Хасар өмнөөс далдлалдаж,* сумаан онилж хүрэхүйд Бэгтэр үзээд, өгүүлрүүн: "Тайчууд ах дүүгийн гашуун хөнөөл дуусан ядан, өс хорслоон хэн аван чадах хэмээж бүхүйд, намайг яахан нүдний сормуус, амны хахаас болгомуй, та нар?"

Сүүдрээс бус нөхөр үгүй
Сүүлнээс бус чичуга үгүйд,

яахан тийн сэтгэв, та нар? Голомтыг минь бүү бүрэлгэгтүн! Бэлгүдэйг бүү тэвчигтүн!* хэмээгээд завилан сууж, хүлцэв*. Тэмүжин Хасар хоёр өмнөөс, умраас үтэр харваж одов.

* **өчигөн** - *өчигдөр*
* **годил сум** - *харвуулын сумны төмөр зэвийн оронд бяцхан булцуу хийсэн сум*
* **годилдсоныг** - *годил сумаар харавсаныг*
* **улхан** - *довцог толгой*
* **далдлалдаж** - *биесээ далдалж*
* **Бэлгүүдэйг бүү тэвчигтүн** - *Бэлгүүдэйг бүү хөнөөгтүн*
* **хүлцэв** - *хүлээв*

78. Гэрт ирж, орохуй лугаа, Үжин эх хоёр хүүхдийнхээн царайг ухаж, өгүүлрүүн:

"Ханиан барагсад
Халуунаас минь
Халтхийн гарахдаа
Гартаан хар нөжин атган төрлөө, энэ!
Харвисаан хазах*
Хасар нохой мэт
Хаданд довтлох хаблан* мэт
Агуураан* даран ядах арслан мэт
Амьд залгих хэмээх мангас мэт
Сүүдэртээн довтлох шонхор мэт
Сэмээр залгих цурхай мэт.
Ботгоныхоон борви хазах буур мэт
Бороонд довтлох чоно мэт
Хөвүүдээн гилэн* ядаж
Хөвүүдээ идэх ангир мэт
Хэвтшээн хөндвөөс өмөөрөх цөөвөр мэт
Барьж үл саарах барс мэт
Балмад довтлох баруг* мэт барав.
Сүүдрээс бус нөхөр үгүйд
Сүүлнээс бус чичуга үгүйд

Тайчууд ах дүү нарын гашуун хөнөөл дуусан ядан бүхүйд, өс хорслоон хэн авах хэмээж бүхүйд, хэр (хэрхэн) байя хэмээн ийн хийлдмүй, та нар" хэмээн хөвүүдээн

Хуучин үгс хадлан*

Өтгөс үгс орхидон* маш муулав.

* ***харвис*** *– ихэс хойдох буюу түүний хальс*
* ***харвисаан хазах*** *– ихэсийн хүйгээ тас хазах*
* ***хаблан*** *- барс ирвэсийн нэгэн зүйл*
* ***Агуурааи*** *- Уураа*
* ***хадлан*** *– хадаан хэлэх*
* ***орхидон*** *– эш татах*
* ***гилэн*** *– хөөж түүн*
* ***баруг*** *– урт үст нэгэн зүйл нохой*

79. Төдий атал Тайчуудын Таргудай Хирилтуг турхагуудаан* удирдаж

"Хулхи гоожжухуй,
Шүлс шивэрчүхүй*"

хэмээн ирэв. Эхэс хөвүүд, ах нар дүү нар айж, ой шугуйд шургалж, Бэлгүдэй мод хуга таталж, шивээ барьж, Хасар харвалалдаж, Хачигун, Тэмүгэ, Тэмүлүн гурвыг уулын зав жалгад нууж, булхалдан* бүхүйд, Тайчууд бархиран өгүүлрүүн: "Ахыгаан, Тэмүүжинийг илгээ! Бусад, та нарын хэрэггүй" хэмээн бархирахад, Тэмүүжинийг морилуулж буруулуулан, ойд дутааж одохуйг Тайчууд үзэж үлдэж,* Тэргүүн өндөрийн шугуйд шургаж орвоос, Тайчууд орон ядан, шугуйд орчин сахижухуй*.

* ***турхаг*** *– хамгаалах шадар цэрэг, торгон цэрэг*
* ***Хулхи гоожжухуй, Шүлс шивэрчүхүй*** *– Чихний хулхи нь гоожихоо больж, шүлс нь савирахаа байж, том болсон гэсэн утгатай хэлц үг.*
* ***булхалдан*** *– тэмцэлдэн, хатгалдан*
* ***үлдэж*** *– нэхэж хөөж*
* ***орчин сахижухуй*** *– тойрон сахижухуй*

80. Тэмүжин шугуй дотор гурав хонож, "Гарсу*" хэмээн морион хөтөлж айсахуйд, мориноос эмээл инү мүлтэрч хоцорчухуй. Эргэж үзвээс, эмээл хөмөлдрөглөсөөр, оломлосоор атал мүлтэрч хоцорчухуй.

Олом ч болтугай, хөмөлдрөг бас хэр (хэрхэн) мүлтрэх бүлгээ. Тэнгэр ятган аху юу? хэмээн харьж, бас гурав хонов. Бас гарч айсахуйд шугуйн амсарт хошлогийн төдий* цагаан гүр* амсар бөглөн унажухуй. Тэнгэр ятган аху юу? хэмээж харьж, бас гурав хонов. Бас есөн хоног идээн үгүй аж. "Нэр үгүй хэр ингэж үхэх? Гарсу" хэмээж, тэр амсар бөглөн унасан хошлогийн төдий цагаан гүрийг орчин (тойрон) гарваас, үл болох мододыг сумч хутугайгаараа* огтлоод, морио хальтруулан гарахуй лугаа, сахиж байсан Тайчууд барьж авч одов.

* ***гарсу*** *– гарья*
* *аху- байх*
* ***хошлогийн төдий*** *– бага гэрийн төдий*
* ***цагаан гүр*** *- цагаан чулуу*
* ***сумч хутугайгаараа*** *– сумын мөс засдаг хутгаараа*

81.Тэмүжинийг Таргудай Хирилтуг авч одож, улс иргэндээн засаглаж*, айлд нэг хонуулан хонуулан*, бидүүлэн* явахуйд зуны тэргүүн сарын арван зургааны улаан тэргэл өдөр Тайчууд Ононы эрэг дээр хуримлалдаж, наран шингэвээс тархав. Тэмүжинийг тэр хуримд* нэг хялбар хөвүүн хүмүүн авч ирж бүлгээ. Хуримын хүмүүсийг тархуулан, тэр хялбар хөвүүнээс бугуугаа* татаж авч, эхэн орой уруу ину нэгэнтээ дэлдээд* гүйж, Ононы түн* дотор хэвтвээс үзэгдэх хэмээж, усны харигт гэдрэг харж хэвтээд, бугуугаа усан уруу урсган, нүүр ил хэвтэв.

* ***засаглаж*** *- залхаан шийтгэж*
* ***айлд нэг хонуулан хонуулан*** *- айл бүрд нэг нэг хонуулан*
* ***бидүүлэн*** *- хэсүүлэн*
* ***хурим*** *- найр наадам*
* ***бугуугаа*** *- модон дөнгөө*
* ***эхин орой уруу ину нэгэнтээ дэлдээд*** *- толгой уруу нь нэг удаа цохиод*
* ***Ононы түн*** *- Ононы битүү шигүү хар шугуй*

82. Тэр алдсан хүмүүн их дуугаар "Бариа хүмүүнийг* алдав" хэмээн бархирахуйд тархсан Тайчууд хуриж ирж,

Хоньчин, хургачин бидний
Хоолойд* хүртүгэй" хэмээв.

Тэмүжин Жамухын энэ үгийг ухан ядаж, сэмээр байж хоцорч, нүүр думд тэргэдээн хүлээж*, Тэмүжин Өгээлүн эхэд: "Жамуха анд өгүүлмү.

"Ууланд шахан бууя.
Адуучин, бидний
Алачугаа хүртүгэй.
Голд шахан бууя.
Хоньчин, хургачин бидний
Хоолойд хүртүгэй" хэмээн өгүүлмү. Би энэ үгийг инү ухан ядаж, хариу ину юу бээр эс өгүүлэв*. Эхээс асуусу* хэмээн ирэв, би" хэмээв. Өгээлүн эхийг дуугараагүй байхад Бөртэ үжин өгүүлрүүн:" Жамуха анд уйданга хэмээгдэн бүлгээ. Эдүгээ биднээс уйдах цаг болов. Тугаарын Жамуха андын хэлсэн хэл* биднийг жишээлсэн үг* буюу. Бид бүү бууя. Энэ хөдөлсөөр шулуухан хагацаж, шөнө дүлин хөдөлье" хэмээв.

* ***асан*** *- байсан*
* ***алачугаа*** *– хөдөө хээр авч явах нэгэн зүйл нүүдлийн орон гэрт*
* ***хоолой*** *– хоол, идээн*
* ***нүүр думд тэргэдээн хүлээж*** *– нүүдэл дунд тэргүүдээ хүлээж*
* ***хариу ину юу бээр эс өгүүлэв*** *– түүний хариуд юу ч эс хэлэв*
* ***асуусу*** *- асууя*
* ***хэлсэн хэл*** *– хэлсэн үг*
* ***биднийг жишээлсэн үг*** *– бид нэгэн санаатан байж чадахгүйг битүүгээр хэлсэн үг*

119. Бөртэ үжиний үгээр зөвшөөж, үл буун, шөнө дүлин хөдөлж айсахуйд, зуур мөрт Тайчуудыг дайрав. Тайчууд бээр хөхиж*, мөн шөнө бөгөөд Жамухын зүг зөрчин хөдлөв*. Тайчуудын Бэсүдийн нутагт, нэгэн өчүүхэн Хөхөчү нэрт хөвүүнийг нутагт хоцорсныг биднийхэн аваад, ирж, Өгээлүн эхэд өгөв. Өгээлүн эх тэжээв.

* ***хөхиж*** *– цочин сандарч*
* ***зөрчин хөдлөв*** *– зөрөн дүрвэв*

120. Тэр шөнө дүлиж, өдөр гийхүйд үзвээс, Жалайрын Хачигун Тохируун, Харахай Тохируун, Харалдай Тохируун, эд гурван Тохируун ах нар дүү нар шөнө дүлилдэж айсун ажгуу. Бас Таргудын Хадаан Далдурхан ах нар дүү нар таван Таргуд айсун ажгуу. Бас Мэнгэтү хианы хөвүүн Өнгүртан* Чаншигуд Баягуудаараан айсун ажгуу. Баруласаас Хубилай Худус ах нар дүү нар ирэв. Мангудаас Жэтэй Доголху чэрби* ах дүү хоёр ирэв. Боорчугийн дүү Өгэлэн чэрби Аруладаас хагацаж, ахдаан, Боорчу-д нийлэн ирэв. Зэлмэ-гийн дүү Чагурхан, Сүбээдэй баатар Урианханаас хагацаж, Зэлмэд нийлэн ирэв. Бэсүдээс Дэгэй Хүчүгүр ах дүү хоёр ирэв. Сүлдүсээс Чилгүдэй, Тахай, Тайчуудай ах нар дүү нар ирэв. Жалайрын Сэцэ Домог Архай Хасар, Бала хоёр хөвүүдээрээ өөрөө ирэв. Хонхотанаас Сүйхэтү чэрби ирэв. Сүхэхэний Жэгэй, Хонтахорын хөвүүн Сүхэхэй Жэгүн ирэв. Нэгүдэй Цагаан-Ува ирэв. Олхунуудын Хингияадай, Горлосоос Сэчигүр, Дөрбэнээс Мөчи-бэдүүн ирэв. Ихирэсийн Буту энд хүргэдэд явсаар* ирэв. Ноёхоноос Жунсо ирэв. Оронараас Зургаан ирэв. Баруласаас Суху сэцэн, Харачар хөвүүн лүгээ бээн ирэв. Бас Баарины Хорчи Үсүн өвгөн, Хөхөчөс Мэнэн Бааринаараан нэгэн хүрээн ирэв.

* ***Өнгүртан*** *- Өнгүр тэргүүтэн*
* ***чэрби*** *– эртний түшмэлийн цол*
* ***хүргэдэд явсаар*** *- хүргэн болж, хадамд соригдон явсаар*

121. Хорчи ирж өгүүлрүүн: "Бодончар богдын барьж авсан эмээс төрсөн, бид. Жамуха лугаа

Хээл нэгтэн
Хэхэ гагцтан* бүлгээ, бид.

Жамухаас үл хагацах учиртай билээ, бид. Заарин* ирж, надад нүдэнд үзүүлэв. Ухаагч үнээ ирж, Жамухыг орчиж явж, гэр тэргийг инү мөргөлөөд, Жамухыг мөргөж,

өрөөл эврээн хугалж, солжир эвэрт болж, "Эврийг минь ац!" хэмээн хэмээн, Жамухын зүг мөөрөн мөөрөн, шороо сацан сацан байму. Мухлар ухаа үхэр их гэрлүгэ*-г дээр өргөж, хөлж зүтгэж, Тэмүжиний хойноос их тэргүүрээр* мөөрөн мөөрөн айсахдаа:

"Тэнгэр газар эетэлдэж*
Тэмүжинийг улсын эзэн болтугай"

хэмээн улс тээж авч айсуй хэмээн заарид* нүдэнд үзүүлж, надад заамуй. Тэмүжин чи улсын эзэн болбоос, намайг заасны тул хэр жаргуулах, чи" хэмээв. Тэмүжин өгүүлрүүн: "Үнэн тийн улс мэдүүлвээс, түмний ноён болгосу" хэмээв.

"Эл өдий төрийг заасан хүмүүнийг, намайг түмний ноён болговоос юун жаргалан буй. Түмний ноён болгоод, улсын гоос* сайн охид дархлан авахуулж*, гучин эмст болго. Бас юу хэлснийг минь эсрэг сонс*!" хэмээв.

* ***хэхэ*** *– Хүүхэд нялхасын ихэс хойтхи*
* ***заарин*** *– тэнгэрийн бошго зарлигийг дамжуулагч, онгон сахиус (Хожим бөөг заарин гэх болжээ.)*
* ***гэрлүгэ*** *– гэр тэргийн шалыг тулах тулгуур багана*
* ***их тэргүүрээр*** *– өргөн их замаар*
* ***тэнгэр газар эетэлдэж*** *– эцэг тэнгэр, эх этүгэн зөвшөөж*
* ***заарид*** *– зааринууд, олон онгод сахиус*
* ***гоос*** *– олон гоо*
* ***дархлан авхуулж*** *– авах дархан эрх олгож,*
* ***эсрэг сонс*** *– халз харж, анхаарч сонс!*

122. Хунан тэргүүтэн Гэнигэс нэгэн хүрээн ирэв. Бас Дааридай Отчигин нэгэн хүрээн ирэв. Жадаранаас Мулхалху ирэв. Бас Үнжин Сахайт нэгэн хүрээн ирэв. Жамухаас төдий хагацан хөдлөөд, Химурга горхины Айл харганад бууж бүхүйд бас Жамухаас хагацаж, Жүрхиний Сорхату Жүрхийн хөвүүн Сача бэхи, Тайчу хоёр нэгэн хүрээн, бас Нэхүн тайшийн хөвүүн Хучар бэхи нэгэн хүрээн, бас Хутула ханы хөвүүн Алтан Отчигин нэгэн хүрээн, эд бас Жамухаас хагацан хөдөлж, Тэмүжинийг Химурга горхины Айл харганад бууж бүхүйд нийлэн буув. Тэндээс

нүүж, Хүрэлхү дотор Сэнгүр горхины Хар зүрхний Хөх нуурт буув.

123. Алтан, Хучар, Сача бэхи бүрэн эетэлдэж, Тэмүжинээ өгүүлрүүн: "Чамайг хан болгоё. Тэмүжинийг хан болбоос, бид

Олон дайнд
Алгинч агуулж
Өнгө сайн
Охин хатан
Орд гэр,
Харь иргэний
Хацар гоо
Хатан охин
Харгам* сайн агт
Хатируулж авчирч өгсү, бид.
Оро гөрөөс авлаваас
Оройлж хашиж өгсү, бид.
Хээрийн гөрөөсний
Хэвлийг инү нэгдтэл
Шахаж өгсү.
Гууны гөрөөсний
Гуяыг ину нэгдтэл
Шахаж өгсү, бид.
Хатгалдахуй өдөр
Халыг* чинь бус болговоос
Харь ширээс*
Хатан эмээс маань хагацуулж
Хар тэргүүг маань
Газар хөсөрт гээж од !
Энх өдөр
Эеийг чинь эвдвээс
Эрс хараас*
Эм хөвүүдээс мань салгаж